



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

Албан тушаалын тодорхойлолт боловсруулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3, 23.4, Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол, Төрийн албаны Зөвлөлийн 2019 оны “Төрийн жинхэнэ албаны удирдах, гүйцэтгэх албан тушаалд тавигдах тусгай шаардлагыг батлах тухай” 02 дугаар, “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах, нийтлэг журам батлах тухай” 03 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059, 2022 оны А/112 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1, 7.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Нийслэлийн бүтэц, зохион байгуулалтаар байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсонтой холбогдуулан Төрийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Э.Даваахатан	Захиргаа, санхүүгийн Хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Ариунтуяа	Хотын хөгжлийн стандартын Хэлтсийн дарга
	Б.Ариунзаяа	Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Г.Амартүвшин	Байгаль орчны стандартын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	Б.Батчимэг	Стандартын хэрэгжилт, хяналтын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	М.Цогтбилэг	Хот нийтийн аж ахуйн стандартын хэлтсийн Ахлах мэргэжилтэн
	П.Отгонцэрэн	Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн

2.Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулахдаа байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үйл ажиллагааны чиглэлтэй уялдуулан батлагдсан загвар, нийтлэг журмын дагуу боловсруулж ажиллахыг Ажлын хэсэг (Э.Даваахатан)-т үүрэг болгосугай.

3.Ажлын хэсгийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр ханган, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (О.Оджаргал)-д даалгасугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

d:\hotiin_standart\2022_tushaal_blank.docx

1150500041